



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 08 сарын 25 өдөр

Дугаар А/40

Улаанбаатар хот

“Улаанбаатар олон улсын явган аяллын
фестиваль” зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/982 дугаар захирамж, Газрын дүрмийн 7.1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсыг олон улсад сурталчлах, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор “Улаанбаатар Олон Улсын явган аяллын фестиваль”-ийг 2023 оны 08 дугаар сарын 25-27-ний өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Арга хэмжээний төсвийг хавсралтаар баталж, шаардагдах 39,380,000 (Гучин есөн сая, гурван зуун наян мянга) төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч (Д.Уянга)-д зөвшөөрсүгэй.

3. Арга хэмжээг зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөөг батлуулж, нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулахыг Бодлогын хэрэгжилтийн хэлтэс (В.Батчимэг)-т даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

115050019

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2023 оны 08 сарын 25 өдрийн
АНО дугаар тушаалын хавсралт

“УЛААНБААТАР ОЛОН УЛСЫН ЯВГАН АЯЛЛЫН ФЕСТИВАЛЬ”
АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН ЗАДАРГАА

2023 оны 08 дугаар сарын 24-ний өдөр

Улаанбаатар хот

№	Зардлын зүйл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Тайз хөгжим техник түрээс /4x3 хэмжээтэй/	Багц 3 өдөр	10 000 000	10 000 000
2	Хөтлөгчийн зардал	Багц 3 өдөр	1 500 000	1 500 000
4	Цахим сүлжээгээр олон нийтэд сурталчлан бүүст хийх	Багц 7 өдөр	1 000 000	1 000 000
5	Хэвлэлийн зардал /анонс эх бэлтгэл, маршрутын танилцуулга, туг/	Багц	2 000 000	2 000 000
6	Урлагийн тоглолт зохион байгуулах	Багц 3 өдөр	2 000 000	5 000 000
7	Алхалтын батламж /гарын бэлэг/	200 ш	5000	1 000 000
8	Гадаад зочдын зочид буудлын зардал	6 хүн 4 өдөр	295 000* 6 хүн 4 өдөр	7 080 000
9	Гадаад зочдын тээврийн зардал	4 өдөр	3 000 000	3 000 000
10	Морин циркийн үзүүлбэр	1 өдөр	4 000 000	4 000 000
11	Гадаад зочдын хоолны зардал	6 хүн 4 өдөр	200 000	4 800 000
Нийт дүн				39,380,000

--- оОо ---